

МОНГОЛ УЛСЫН СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО

АСУУВАЛ ХАРИУЛЪЯ.

Эрхэм сонгогч та сонирхсон асуултаа манай цахим хаягаар илгээж болно. Таны асуултад Сонгуулийн Ерөнхий Хорооны Ажлын албаныхан хариулах болно.

А: Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль хэзээ болох вэ?

Х: Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль 2021 оны 06 дугаар сарын 09-ний өдөр өглөөний 07,00 цагаас оройн 20,00 цаг хүртэл хугацаанд санал хураана. Сонгогч та бүхэн аль болох эртхэн очиж санал хураалтандаа идэвхтэй оролцоорой.

А: Би энэ жил 18 нас хүрч, анх удаа сонгууль өгөх гэж байгаа. 18 насанд хүрсэн хүн болгон саналаа өгөх эрхтэй юу?

Х: Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэн гэж 18 нас хүрсэн хүнийг хэлдэг. Гэхдээ 18 нас хүрсэн гэдэгт төрсөн он, сар, өдрөөс тоолоход сонгуулийн санал авах өдөр буюу түүнээс өмнө нь насанд хүрсэн байх ёстой. Мөн эрх зүйн бүрэн чадамжтай иргэд саналаа өгнө.

А: Эрх зүйн чадамжгүй иргэн гэдэгт ямар хүнийг хамааруулж ойлгох вэ?

Х: Эрх зүйн чадамжгүй гэдэг нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон, эсвэл хорих газар ял эдэлж байгаа болон түр чөлөөгөөр гарсан, хорих ял эдлэхээс зайлсхийж яваа иргэн гэж ойлгох хэрэгтэй. Эдгээр иргэд сонгуульд оролцох эрх эдэлдэггүй.

А: Манайх сумын төвөөс нилээд хол байдаг. Санал өгөх гэж хэсгийн хороо руу явахад хонь мал эзгүйдэхээс эхлээд нэлээд асуудал гардаг. Гэр бүлийнхээ хүнээр төлөөлүүлж саналаа өгөх боломж байдаг уу?

Х: Уучлаарай, тийм боломж байхгүй. Учир нь Монгол Улсын иргэн бүр сонгуульд хэн нэгний төлөөлөлгүйгээр биечлэн оролцож, саналаа нууцаар, чөлөөтэй гаргах эрхтэй гэж хуульд заасан байдаг юм.

А: Манай ах, эгч хоёр одооноос эхлээд л намайг өөрсдийнхөө дэмждэг намын төлөө саналаа өгөөрэй гээд байх юм. Миний хэнд саналаа өгснийг хэн нэгэн мэдэх боломж байдаг уу?

Х: Сонгуульд оролцох эсэхээ зөвхөн чи өөрөө л бие даан шийдэх эрхтэй. Мөн таны хэнд саналаа өгснийг хэн нэгэн мэдэх боломжгүй. Учир нь сонгогч саналаа нууцаар гаргах эрхээр хангагдсан байдаг.

А: Манай хүү олон улсын энхийг сахиулах ажиллагаанд оролцож Сьерра-Леон улсад алба хааж байгаа. Энэ улсад Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газар байдаггүй. Тэгэхээр тэнд алба хааж байгаа цэрэг, дайчид маань саналаа өгөх боломж бий юу?

Х: Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газар байрладаг гадаад улсад байгаа сонгуулийн эрх бүхий иргэдийн саналыг авахаар МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд заасан. Сьерра-Леон улсад Монгол улсын дипломат төлөөлөгчийн газар байхгүй учир энэ удаа хүү тань сонгуульд оролцох боломжгүй юм.

Ер нь гадаад улсад ажиллаж амьдарч байгаа иргэд саналаа хэрхэн өгөх талаар Сонгуулийн ерөнхий хорооны http://gec.gov.mn/for_elector/44/133 цахим хуудаснаас мэдээлэл аваарай.

А: Би Солонгост ажилладаг. Бид нар Монголдоо байгаа хүмүүстэй адил, нэг өдөр саналаа өгөх үү. Заавал иргэний үнэмлэхтэй байх ёстой юу?

Х: Үгүй ээ. Гадаадад байгаа иргэд маань саналаа өгөхөөр очихдоо иргэний үнэмлэх, эсвэл үндэсний гадаад паспорттой байна. Гадаад улсад байгаа сонгуулийн эрх бүхий иргэний саналыг 2021 оны 05 дугаар сарын 30,31-ний өдрийн Даваа, Ням гарагуудад тухайн улсын орон нутгийн цагаар 07-22 цагийн хооронд гадаад дахь сонгогчдын саналыг авахаар Сонгуулийн ерөнхий хорооноос товлосон. Гадаад оронд байрлаж буй дипломат төлөөлөгчийн газарт нийтгаруй иргэд сонгуульд оролцож саналаа өгөхөөр бүртгүүллээ. Гадаад улсад буй Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газрын талаарх мэдээллийг Гадаад харилцааны яамны http://www.mfat.gov.mn/index.php?option=com_content&view=category&layout=blog&id=65&Itemid=89&lang=mn сайтаас аваарай.

А: Гадаадад ажиллаж, амьдарч байгаа монгол иргэд сонгуульд саналаа хэрхэн өгөх вэ? Миний Монгол дахь хаяг Баянгол дүүрэгт бүртгэлтэй. Би дүүрэгтээ нэр дэвшиж байгаа хүмүүсийн төлөө саналаа өгөх боломжтой болов уу?

Х: Тийм боломж байхгүй. Та хэдийгээр Баянгол дүүрэгт бүртгэлтэй ч гэлээ, харьяа хэсгийн хороо дээрээ биеэрээ очиж сонгуулийн санал өгөх боломжгүй. Тийм учраас та хуульд заасны дагуу гадаад улсад байгаа дипломат төлөөлөгчийн газарт сонгуульд оролцохоо мэдэгдэн 5 дугаар сарын 30,31-ний өдөр очиж сонгуульд оролцож байгаа нэр дэвшигчдээс сонгон саналаа өгөх нь. Саналаа тэмдэглэхдээ өөрийн сонгохыг хүссэн 1 нэр дэвшигчийн өмнөх улаан хүрээ бүхий дугуйг тусгай үзгээр дүүргэн будаж тэмдэглэнэ.

А: Энэ удаагийн сонгуулийг ажлын өдөр болно гэж сонслоо. Тэр өдөр нь ажилтай бол яах вэ. Санал авах өдрийг хаанаас, хэзээ тогтоодог талаар мэдээлэл өгөөч?

Х: Монгол Улсын Их Хурал ээлжит сонгуулийг сонгуулийн жилийн 02 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө товлон зарлаж, санал авах өдрийг тогтооно. Энэ жилийн Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг 2021 оны 6 дугаар сарын 09-ний /Лхагва/ гаригт авахаар зарласан бөгөөд энэ өдрийг бүх нийтийн амралтын өдөр болгосон. Тэр өдөр Та ажиллаж байвал ажлаа зохицуулаад өглөөний 07 цагаас оройн 20 цагийн хооронд харьяа хэсгийн хороон дээрээ очоод саналаа

өгөөрэй. Таны ажиллаж буй байгууллагын захиргаа саналаа өгөх боломжоор тань хангах үүргийг хуулиар хүлээсэн байгаа.

А: Би хөдөө томилолтоор байнга явдаг ажилтай. Санал авах өдөр оршин суугаа газраасаа өөр газарт байвал сонгогчийн шилжүүлгээ яаж хийлгэх, хэд хоногийн өмнө шилжилтээ бүртгүүлсэн байх ёстой талаар тодруулж өгөөч?

Х: Сонгуулийн хуульд сонгогч санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө хүсэлтээ холбогдох баримтын хамт харьяа хэсгийн хороонд ажиллах иргэний бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтанд, эсхүл улсын бүртгэлийн холбогдох байгууллагад биечлэн гаргана.

А: Хуульд сонгуулийн мөрийн хөтөлбөр, сурталчилгааг нэг бүлэг болгосон нь ямар учиртай юм бол ?

Х: Эдгээр асуудал хоорондоо салшгүй холбоотой. Мөрийн хөтөлбөрт Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хүрээнд нэр дэвшигчийн баримтлах үзэл баримтлалыг тодорхойлсон байдаг. Тийм учраас хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мөрийн хөтөлбөрийг тайлбарлан таниулах нь сурталчилгааны гол бүрэлдэхүүн хэсэг гэж ойлгож болно.

А: Сонгуулийн үеэр маш олон тооны ухуулагч нар яваад байдаг. Нэр дэвшигчийн ухуулагч, шадар туслагчийн тоог хуульд тодорхой заасан байдаг уу. Үүнд хэрхэн хяналт тавьдаг вэ?

Х: Нэр дэвшигчийн сонгуулийн бэлтгэл ажил, нэр дэвшигчээс сонгогчидтойгоо уулзах, сонгуулийн мөрийн хөтөлбөрөө сурталчлах зэрэг сонгуулийн сурталчилгааг зохион байгуулахад намын сонгууль эрхэлсэн байгууллага, түүний ажилтан, нэр дэвшигчийн шадар туслагч, ухуулагч тусална.

Нэр дэвшигч өөрийн итгэмжлэл олгосон нэг ерөнхий менежер, аймаг, нийслэл дүүрэг тус бүрд нэг менежер, баг хороо тус бүрд нэг шадар туслагчтай, 200 сонгогч тутамд нэг ухуулагчтай, байхаар хуульчилсан. Хэрэв тухайн аймаг, дүүргийн сонгогчийн тоог 200-д хуваасны үлдэгдэл нь 200-аас доош, 100-аас дээш бол тэдгээр сонгогчийг хариуцсан нэг ухуулагч ажиллаж болно.

Намын сонгууль эрхэлсэн байгууллага нь улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулах 200 хүртэл, нийслэлд 100 хүртэл, аймаг, дүүрэгт 50 хүртэл, хороонд 20 хүртэл ажилтантай байж болохоор хуульд заасан. Эдгээр шадар туслагч, ухуулагч, намын ажилтнуудыг сонгуулийн хороод бүртгэж үнэмлэх олгодог учраас үүнд хяналт тавих боломжтой.

А: Сонгогч саналаа өгөхөд юуг анхаарах вэ?

Х: Санал тэмдэглэх тухай зааврыг сонгогчдод хүргэж байгаа сурталчилгаанаас авч болно. Мөн санал тэмдэглэх бүхээг, саналын хуудсанд дээр тодорхой бичигдсэн байгаа тул сайтар уншиж танилцаарай.

Саналын хуудсанд нэр дэвшигчийн зураг тавигдсан байгаа. Мөн эцгийн нэр, өөрийн нь нэр, нэр дэвшүүлсэн намын нэрийн бичсэн. Тиймээс ойлгомжгүй

зүйл гарахгүй. Харин Та зөвхөн нэг нэр дэвшигчийн нэрийн өмнөх улаан хүрээтэй зууван дугуйг дүүргэн будах хэрэгтэй. Нэгээс илүү нэр дэвшигчийн төлөө санал өгвөл таны санал хүчингүй болж нэр дэвшигчдэд өгсөн саналд тооцогдохгүй.

А: Саналын хуудсанд УИХ-ын сонгуулийнхтай адилхан тэмдэглэл хийх үү? Саналын нууцлалыг хэрхэн хангаж байгаа вэ?

Х: Тиймээ. Та саналын хуудсанд бичигдсэн нэр дэвшигчдийн дотроос сонгохыг хүссэн нэг л нэр дэвшигчийн нэрийн өмнөх зууван дугуйг санал тэмдэглэх бүхээгт байх зориулалтын үзгээр дүүргэн будна. Саналаа тэмдэглэсний дараа хэсгийн хорооноос өгсөн саналын хуудасны хавтсанд саналын хуудсаа хийж санал тоолох төхөөрөмж рүү очно. Харин санал тоолох төхөөрөмжид уншуулахдаа саналын хуудсаа хавтаснаас нь гаргаж байж хийгээрэй.

А: Сонгуулийн үеэр тойрог, хэсгийн хороодод ажиллаж байгаа хүмүүс аль нэг улс төрийн нам, нэр дэвшигчдэд үйлчлэх явдал гардаг байсан. Одоогийн хуулиар ийм хүмүүст ямар хариуцлага хүлээлгэх вэ?

Х: Энэ тухай Сонгуулийн хуульд тодорхой заасан байгаа. Тухайлбал, тойргийн болон салбар, хэсгийн хороодын дарга, нарийн бичгийн дарга, гишүүд сонгуульд оролцож байгаа аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар сурталчилгаа явуулах, энэ зорилгоор сонгогчоос сонгох эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулах, нөлөөлөх үйлдэл гаргавал хариуцлага тооцно. Түүнчлэн санал хураах, тоолох ажилд санаатайгаар саад хийх, бусдыг төлөөлж санал өгөх, зөврийн битүүмжилсэн саналын хайрцаг болон санал тоолох төхөөрөмжийн лац, битүүмжлэлийг гэмтээх, гарын үсэг хуурамчаар үйлдэх, саналын хуудас солих, хүчингүй саналын хуудсаар санал авах зэрэг хууль бус аливаа үйлдэл хийх, зохион байгуулах, бусад хэлбэрээр дэмжихийг хориглоно гээд тодорхой заасан байдаг.

Хориглосон заалтыг зөрчвөл зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэхээс гадна эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Хэрвээ гаргасан зөрчил нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй байвал сонгуулийн хорооны бүрэлдэхүүнээс хасах бөгөөд энэ нь төрийн албан хаагчийг төрийн албанд нь нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах үндэслэл болно.

А: Би өөрийн болон гэр бүлийнхнийгээ сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн эсэхийг хаанаас, яаж шалгах боломжтой вэ. Хэрэв бүртгэгдээгүй эсвэл буруу бүртгэгдсэн байвал хэнд хандах вэ?

Х: Сонгогчдын нэрийн жагсаалтыг Улсын бүртгэлийн ерөнхий газраас дөрөвдүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сонгууль дуустал цахим хуудсандаа байршуулж, нийтэд танилцуулж эхэлсэн. Та www.burtgel.mn гэсэн хаягаар орж өөрийн болон гэр бүлийнхнийхээ нэрийг сонгогчдын нэрийн жагсаалтад байгаа эсэхийг шалгаарай. Сонгогч өөрийнхөө нэрийг сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэлтэй байгаа эсэхээ санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө буюу 5 дугаар сарын 26-наас өмнө шалгасан байх шаардлагатай. Хэрэв таны нэр сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй, эсвэл буруу бүртгэгдсэн байвал гомдлоо харьяа сум, дүүргийн хэсгийн хороондоо гаргана уу. Таны гомдлыг тэд

ажлын хоёр өдрийн дотор шийдвэрлэж өгөх үүрэгтэй. Харин санал авах өдөр сонгогчдын нэрийн жагсаалтад аливаа өөрчлөлт оруулахыг хуулиар хориглосон гэдгийг анхаараарай.

А: Өнгөрсөн сонгуулиудаар сонгогчдын нэрийн жагсаалтыг хэсгийн хорооны гишүүд айл, өрхөөр явж тулгалт хийгээд үйлддэг байсан. Одоо сонгогчдын нэрийн жагсаалтыг хаанаас гаргах вэ?

Х: 2010 онд Монгол Улс хүн амын тооллого явуулж, иргэдийг шинэчилсэн бүртгэлд хамруулсан. Энэхүү иргэний бүртгэлийн улсын санд тулгуурлан Улсын бүртгэлийн ерөнхий газар сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэж, нягтлан шалгах, давхардлыг нь арилгах, бүртгэгдээгүй буюу буруу бүртгэгдсэн иргэнийг бүртгэх зэрэг ажлуудыг улсын хэмжээнд зохион байгуулдаг.

А: Сонгуулийн санал авах өдөр саналаа өгөхөөр очиход сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй байвал яах вэ?

Х: Танд өөртөө цаг гаргаад санал авах өдөр бус түүнээс 14 хоногийн өмнө сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэлтэй эсэхээ шалгасан байх шаардлагатай. Учир нь хуулиар сонгуулийн санал авах өдөр нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулахыг хориглосон байгаа. Түүнчлэн Таны харьяа хэсгийн хороо чинь 6-р сарын 06-ны өдрөөс эхлэн сонгогчдын нэрийн жагсаалтыг өөрийн байранд ил тавьж, иргэдэд чөлөөтэй танилцах боломжоор хангана.

А: Би хөдөө томилолтоор байнга явдаг ажилтай. Миний хувьд сонгогчийн шилжүүлгээ хийлгэн санал өгөх газраа бүртгүүлчихсэн байгаа. Манай ажлын хүмүүс зарим нь шилжүүлгээ хийлгээгүй байсан. Одоо хийлгэж болох уу. Мөн сонгогчийн үнэмлэх өгөх үү?

Х: Сонгуулийн хуульд сонгогчийн шилжилтийг санал авах өдрөөс 60 хоногийн өмнө буюу 4-р сарын 10-наар дуусгавар болгохоор заасан. Тиймээс сонгогчийн шилжүүлэг зогссон байгаа. Энэ удаагийн сонгуульд сонгогчдод сонгогчийн үнэмлэх өгөхгүй. Та бүхэн зөвхөн иргэний үнэмлэхээ авч харьяа санал авах байрандаа очиж саналаа өгнө. Энэ удаагийн сонгуулиас эхлээд сонгогчийн бүртгэлтэй холбоотой бүхий л асуудлыг Улсын бүртгэлийн ерөнхий газар хариуцаж байгаа.

А: Би Баянзүрх дүүргийн 3-р хороонд бүртгэлтэй байдаг боловч Чингэлтэй дүүрэгт амьдардаг. Сонгогчдын нэрийн жагсаалтад аль хаягаараа бүртгэгдэх вэ?

Х: Та иргэний үнэмлэхнийхээ хаягаар сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн байгаа. Баянзүрх дүүргийн 3-р хороо харьяалагдаж байгаа хэсэгтээ очиж саналаа өгөөрэй. Аль хэсгийн хороонд бүртгэлтэй байгаагаа мэдье гэвэл www.burtgel.mn цахим хаягаар орж үзнэ үү.

А: Сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой гомдол гарвал хаана, хэнд, хэрхэн хандах талаар тодруулж өгөөч?

Х: Сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй буюу буруу бүртгэгдсэн асуудлаар гомдлоо итгэмжлэгдсэн ажилтан, эсхүл улсын бүртгэлийн холбогдох байгууллагад санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө гаргаарай.

А: Миний иргэний үнэмлэхийн хугацаа дууссан. Одоо лавлагааны бичигтэй байгаа. Энэ тохиолдолд ямар журмаар сонгуульд оролцох вэ?

Х: Сонгогч санал авах байранд иргэний үнэмлэхтэйгээ ирж саналаа өгнө. Иргэний үнэмлэхийн хугацаа дууссан тохиолдолд лавлагааны бичигтэй байж болно. Гэхдээ гарын хурууны хээгээ таниулж, саналаа өгөх боломжтой тул та санал авах байранд ирж саналаа өгч болно.

А: Сонгуульд оролцохдоо иргэд хурууны хээгээ шалгуулж саналаа өгнө гэсэн. Ингэснээр сонгогч дахин санал өгөхөөс сэргийлэх боломж бүрдэж байна гэж ойлгож байна.

Х: МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд сонгогчийн бүртгэлийн програм хангамжийг ашиглана. Сонгуулийн хэсэг тус бүрээр ангилсан сонгогчийн хурууны хээний мэдээллийг ашиглах бөгөөд сонгогч санал авах байранд очиж саналаа өгөхдөө хурууны хээ унших төхөөрөмжид хурууны хээгээрээ шалгуулахад бүртгэлийн програмд тухайн сонгогчийн зураг бүхий мэдээлэл гарна. Сонгогчийн мэдээллийг шалгасны дараа тухайн хэсэгт бүртгэлтэй сонгогчид “Бүртгэлийн хуудас” хэвлэж өгнө. Тэрхүү бүртгэлийн хуудсыг хэсгийн хорооны гишүүнд шалгуулан саналын хуудас авна. Ингэснээр Та санал өгөх эрхтэй болно гэсэн үг.

А: Сонгуульд нэр дэвшигчдийн нэрс хэзээ тодрох вэ. Нэр дэвшигчдэд хандив өгвөл яаж өгөх талаар тодруулна уу?

Х: МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийг бүртгэх ажил 5-р сарын 08-ны өдөр дуусна. Тиймээс хуулийн дагуу Сонгуулийн ерөнхий хороо нэр дэвшигчдийг бүртгэсэн тухай шийдвэр гарсан бол нэр дэвшигчийн үнэмлэхийг санал авах өдрөөс 16 хоногийн өмнө нэг өдөр олгож, нийтэд мэдээлэх юм. Хандивын тухайд бол улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчид өгөх хандивын дээд хэмжээг хувь хүнээс гурван сая төгрөг хүртэл, хуулийн этгээдээс арван таван сая төгрөг хүртэл байхаар хуулинд заасан байдаг. Хэрвээ хуулийн этгээд хандив өгөхөөр бол энэ тухай шийдвэрийг түүний эрх бүхий байгууллага гаргасан байх ёстой. Харин та мөнгөн хандив өгөх гэж байгаа бол тухайн нам, эвслийнхээ банкинд нээлгэсэн сонгуулийн дансанд хийгээрэй. Мөнгөн бус хэлбэрээр өгвөл түүнийг мөнгөн хэлбэрт шилжүүлэн үнэлдэг.

А: Нэр дэвшигчдын мөрийн хөтөлбөрт ямар зүйл тусгахыг хориглосон байдаг вэ?

Х: Сонгуульд оролцох нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрт мөнгө, эд хөрөнгө, эд хөрөнгөтэй холбогдсон эрх олгох, уул уурхай, газрын тос, эрдэс баялгийн болон бусад салбарын орлого, түүнчлэн улс, орон нутгийн төсвөөс иргэдэд аливаа хишиг, хувь, тэдгээртэй адилтгах бусад зүйл хүртээх, эсхүл зээлийн болон бусад өр төлбөрийг хүчингүйд тооцох, хөрвүүлэхийг хориглосон байгаа. Түүнчлэн үнэ төлбөргүй болон хямдралтай үнээр үйлчилгээ үзүүлэх, ажлын байранд зуучлах, ажилд оруулах зэрэг амлалт авахаар тусгахыг хориглосон. Энэхүү заалтыг зөрчсөн нэр дэвшигчийг зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэх хуулийн заалттай.

А: Нам эвсэл, нэр дэвшигч сонгуулийн мөрийн хөтөлбөрөө гаргаад аудитын байгууллагаар хянуулж, дүгнэлт гаргуулах болсны учир гэвэл?

Х: Нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцэж байгаа эсэх талаар төрийн аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулна гэж заасан байгаа учраас сонгуульд оролцож буй нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Үндэсний Аудитын газраар шалгуулан дүгнэлт гаргуулна.

А: Сонгуульд нэр дэвшигчид сурталчилгааныхаа ажилд ажилласан хүмүүстээ ажилд оруулахаас эхлээд янз бүрийн амлалт өгөх, аливаа бизнесийг нь дэмжих гэрээ байгуулах явдал байдаг. Энэ нь хуулиар хүлээн зөвшөөрөгддөг үү?

Х: Үүнийг сонгуулийн хуулиар хориглосон байгаа. Тухайлбал, ирээдүйд өөрийн болон бусдын хөрөнгөөр мөнгө, эд бараа өгөхөөр гэрээ байгуулах, аман хэлцэл хийх, хишиг, хувь, хувьцаа өгөх, ажлын байранд зуучлах, ажилд оруулах зэрэг амлалт авахыг хориглосон гэдгийг анхаарна уу.

МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгааг хэдийнээс эхэлсэн гэж үзэх вэ. Яг энэ үеэр ямар үйл ажиллагаа явуулахыг хориглосон байдаг бол...?

Х: Нэр дэвшигч нь сонгуулийн хороонд бүртгүүлж, үнэмлэхээ авсан өдрөөс эхлэн сурталчилгаагаа хийх эрхтэй. Сонгуулийн сурталчилгааг санал авах өдрөөс 24 цагийн өмнө зогсоосон байх ёстой. МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгаа 2021 оны 05 дугаар сарын 24-ны өдрөөс эхлэж, 2021 оны 06 дугаар сарын 07-ны өдрийг дуустал явагдана. Тэгэхдээ сонгуулийн сурталчилгааны үеэр дараах зүйлийг хориглоно Үүнд:

- Хуульд зааснаас бусад арга хэлбэрээр сонгуулийн сурталчилгаа хийх,
- Зөвшөөрснөөс бусад хугацаанд сонгуулийн сурталчилгаа хийх,
- Сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй аливаа зорилт, арга хэмжээг, хэрэгжүүлэх талаар амлалт авах, ийм агуулга бүхий аливаа үйлдлийг сонгуулийн сурталчилгаанд ашиглах,
- Оройн 22.00 цагаас дараа өдрийн өглөөний 08.00 цаг хүртэлх хугацаанд чанга яригч ашиглахыг хориглоно.
- Олон нийтийг хамарсан аливаа шашны зан үйл ашиглах, түүнийг зохион байгуулах, оролцох, ивээн тэтгэх, шашины ач холбогдолтой эд зүйл тараах зэрэг үйлдлийг хориглосон байдаг.

А: Сонгуулийн сурталчилгааны үеэр телевиз, радиогоор нэр дэвшигчдийн сурталчилгааны нэвтрүүлгүүдээс өөр үзэж сонсох юмгүй шахуу л болдог. Зарим телевизээр нэг намыг хэтэрхий их сурталчлаад, зарим намын нэвтрүүлэг гарахгүй байх шиг байдаг. Энэ ямар учиртай юм бэ?

Х: МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулинд хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа явуулах хэм хэмжээг нь тодорхой заасан байгаа. Тухайлбал, Харилцаа холбооны зохицуулах хороо нь олон нийтийн радио, телевизээр төлбөргүй нэвтрүүлэх сурталчилгааны нэвтрүүлгийн хуваарь, цагийг батлахдаа намаас нар дэвшигчдэд ижил нөхцөл, тэнцүү хугацаа ногдохоор тооцно. Арилжааны телевизээр нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн хуваарьт Харилцаа холбооны зохицуулах хороо хяналт тавьж ажиллана.

А: Ээж минь эрүүл мэндийн шалтгаанаар санал авах байранд очиж санал өгөх боломжгүй тул сонгуульд саналаа яаж өгөх үү.

Х: Та санал авах өдрөөс 3-аас доошгүй хоногийн өмнө өөрийн харьяа хэсгийн хороонд мэдэгдэж, санал авах өдрийн өмнөх өдрийн 09:00-20:00 цагийн хооронд зөөврийн битүүмжилсэн саналын хайрцагаар саналаа өгнө.

А: Сонгуулийн жил эхлэнгүүт л сонгуулийн сурталчилгаа яваад эхэлдэг байсан. Энэ жил харин элдэв тэмцээн уралдаан, найр наадам хийхгүй байх шиг анзаарагдаж байна. Хуулинд энэ талаар яг ямар заалт орсон талаар тодруулж өгөөч?

Х: МУ-н Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд сурталчилгаа явуулахтай холбоотой нэгэн шинэ заалт орсон. Энэ нь ээлжит сонгуулийн жил эхэлснээс хойш буюу 2021 оны 01-р сарын 01-нээс эхлэн санал хурааж дуусталх хугацаанд аливаа этгээд сонгогчдын саналыг татах зорилгоор тодорхой үйлдэл, үйл ажиллагаа явуулахыг хориглосон. Тодруулбал, сонгогчид мөнгө, эд бараа тараах, хөнгөлөлттэй үнээр худалдах, аливаа үйлчилгээ төлбөргүйгээр болон хөнгөлөлттэйгээр үзүүлэх, хурал, цуглаан, биеийн тамирын уралдаан, тэмцээн, баяр наадам, урлагийн тоглолт зохион байгуулах, хүлээн авалт, дайллага, цайллага, төлбөрт таавар, бооцоот, мөрийтэй тоглоом зохион байгуулах, түүнийг ивээн тэтгэх зэрэг сонгуулийн сурталчилгаатай холбогдсон олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахыг хориглосон. Түүнчлэн сонгогчдыг гадаад, дотоодод аялал зохион байгуулан оролцуулах, амралт, сувилалд амраах, сувилуулах, хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон цахим хуудас ашиглан улс төрийн чансаа тогтоох зорилго бүхий аливаа хэлбэрийн шалгаруулалт зохион байгуулах, бусдыг гүтгэн доромжлох, хуурамч мэдээлэл тараах, ирээдүйд өөрийн болон бусдын хөрөнгөөр мөнгө, эд бараа өгөхөөр гэрээ байгуулах, аман хэлцэл хийх, хишиг, хувь, хувьцаа өгөх, ажлын байранд зуучлах, ажилд оруулах зэрэг амлалт авахыг хориглосон зэрэг нь багтсан байдаг.

А: Хэрэв нэр дэвшигчийн талаар хуурамч мэдээлэл тарааж нэр төрийг нь гутаан доромжилбол ямар хариуцлага хүлээлгэх вэ. Сонгууль дөхөөд ирэхээр бие бие рүүгээ дайрч доромжилсон янз бүрийн нэвтрүүлэг их гардаг шүү дээ?

Х: Нэр дэвшигчийг гүтгэх, нэр төрийг нь гутаахыг хуулиар хориглосон. Өөрөөр хэлбэл, нам, эвсэл, нэр дэвшигчийг бэлэн мөнгө, эд бараа тараасан тухай хуурамч мэдээлэл хийн, бусдыг гүтгэвэл эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох хуулийн заалт бий.

А: Сонгогчидтой хийх хурал цуглаан уулзалтын хугацааны талаар тодруулмаар байна. Сонгуулийн компани ажил эхлэхээс өмнө уулзалт зохион байгуулж болох уу?

Х: Нэр дэвшигч үнэмлэхээ авч сонгуулийн сурталчилгаагаа эхлэхээс өмнө уулзалт, цуглаан зохион байгуулж болохгүй. Хэрэв ингэвэл сонгуулийн сурталчилгааны хориглосон заалтыг зөрчсөнд тооцно.

Харин хуульд зааснаар сонгуулийн сурталчилгааны үед уулзалт цуглааныг зохион байгуулж болно. Хугацааны хувьд сонгуулийн сурталчилгааг зогсоох үе буюу санал хураалт болохоос өмнөх өдөр хүртэл уулзалт цуглаан хийж болно.

А: Засаг дарга нар нам эвслийн нэр дэвшигчид тэгш хандах ёстой гэсэн хуулийн заалттай. Гэвч тэд улс төрийн албан тушаалтнууд учраас сонгуулийн үеэр өөрийн намдаа илүүтэй үйлчлэх байдал ажиглагдаад байдаг. Ийм нөхцөлд тэдэнд ямар хариуцлага хүлээлгэдэг вэ?

Х: Энэ тохиолдолд сонгуулийн ажилд туслалцаа үзүүлээгүй, үүргээ биелүүлээгүй хүнийг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор хуульд заасан байгаа.

А: Нэр дэвшигчдийг сонгогчидтой уулзалт, цуглаан хийхэд үнэ төлбөргүй байр гаргаж өгөх ёстой гэх юм. Ямар байгууллагын байрыг ашиглавал төлбөргүй байх юм бэ?

Х: Таны хэлсэнчлэн нэр дэвшигчдийг сонгогчидтой уулзалт, цуглаан хийхэд үнэ төлбөргүй байр гаргаж өгөх ёстой. Үүнд төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь нэр дэвшигчдэд сонгогчдтойгоо хийх уулзалт, хурал, цуглаанд зориулж соёлын төв, биеийн тамирын болон хурлын танхимыг төлбөргүйгээр ашиглуулахаар заасан байгаа.

А: Иргэд, байгууллагаас дэмждэг нэр дэвшигч, намдаа хандив өгөхөөр болбол заавал сонгуулийн дансанд нь хийх үү. Бэлэн мөнгөөр хандив авах уу?

Х: Сонгуулийн хандив мөнгөн болон мөнгөн бус байж болно. Сонгуульд оролцож байгаа нам, эвсэл нь улсын хэмжээнд сонгуулийн нэг данстай байна. Нам, эвсэл, нэр дэвшигчид өгөх хандив нь хуулинд зааснаар хувь хүнээс гурван сая хүртэл, хуулийн этгээдээс арван таван сая төгрөг хүртэл байна.

А: Би аймгийн төвд зочид буудал, цайны газар ажиллуулдаг л даа. Нэр дэвшиж байгаа хүн, намынх нь хүмүүсийг буудалдаа үнэгүй байрлуулж, хоол цайгаар үйлчиллээ гэхэд энэ нь хандивт тооцогддог юм уу?

Х:Тооцогдоно. Учир нь та хандиваа мөнгөн бус хэлбээр өгч байгаа ч түүнийг тооцохдоо мөнгөн хэлбэрт шилжүүлж тооцохоор хуульд заасан учир таны өгсөн хандив нь зардлын дээд хэмжээнээс хэтэрч болохгүй гэдгийг анхаарна уу.

А: Хандив өргөж болохгүй ямар ямар хүмүүс байдаг вэ. Энэ талаарх хуулийн зохицуулалтын талаар тодруулж өгнө үү?

Х: Гадаад улс буюу гадаадын байгууллага, олон улсын байгууллага, төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, гадаад улсын иргэн, иргэний харьяалалгүй хүн, сонгууль товлон зарласан өдөр арван найман нас хүрээгүй Монгол Улсын иргэн, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс хандив авахыг хориглосон. Түүнчлэн шүүхийн шийдвэрээр тогтоогдсон албан татварын өр төлбөртэй, дампуурсан, банкны хугацаа хэтэрсэн зээлийн өртэй хуулийн этгээд, үйлдвэрчний эвлэл, шашны болон бусад төрийн бус байгууллага, байгуулагдаад нэг жил болоогүй хуулийн этгээдээс хандив авахыг хориглосон. Хэрэв дээр дурдсан хуулийн этгээдээс хандив авсан бол нэр дэвшигчийг хасах үндэслэл болно.

А: Нэг барилга байгууламж, цогцолбор дотор хэд хэдэн санал авах байр байгуулж болно гэдгийг тодруулж өгөөч. Санал авах байрны хаяг,

байршлуудыг хаанаас мэдэж болох вэ. Өмнөх сонгуульд санал өгөх хэсгийн хороогоо хайж олох гэж хугацаа алдаж байлаа?

Х: Хэсгийн хороо санал авах байрны дугаар, нэр, хаяг, байршил, шаардлагатай бол орчин тойрны дэвсгэр /план/ зургийг санал авах өдөр хүртэлх 14 хоног хоногийн турш нийтэд зарлан мэдээлэх ёстой.

Харин нэг барилга байгууламж, цогцолборт хэд хэдэн санал авах байр байхаар зохион байгуулж болно гэж заасан. Сонгуулийн хэсгийн хороод байрлах байгаа байрны хаягаа тодорхой зарлан сонгогчдод мэдээлэх үүрэгтэй.

А: Иргэд сонгуулиа өгсний баталгаа болгож хуруундаа бэх түрхүүлдэг. Энэ удаа яах бол?

Х: МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд санал өгсөн иргэдийг баталгаажуулж бэх түрхэнэ. Хөгжлийн бэрхшээлийн улмаас тэмдэглэгээ хийх боломжгүй бол хэсгийн хорооны гишүүн сонгогчийн иргэний үнэмлэхийн мэдээллийг бүртгэж, тэмдэглэл хөтлөнө.

А: Би иргэн хүнийхээ хувиар санал авах байранд байж санал хураалт хуулийн дагуу болж байгаа эсэхийг ажиглаж, харж байж болох уу. Санал авах байранд ямар хүмүүс байхыг зөвшөөрдөг юм бол?

Х: Одоогоор иргэдэд санал хураалт хуулийн дагуу болж байгаа эсэхийг ажиглах боломжийг хуульд тусгаагүй байна. Санал авах байрт хэсгийн хороодын дарга, нарийн бичиг, ажилтнууд, мөн нам эвсэл, бие даан нэр дэвшигчийн томилсон ажиглагч, хэвлэл мэдээллийн ажилтнууд байж болно. Мөн төрийн бус байгууллагуудын ажилтнууд ажиглалт хийхээр болсон.

А: Саналын хуудасны загвар ямар байх талаар тодруулж өгөөч. Саналын хуудсыг хуурамчаар хийхээс сэргийлж ямар арга хэмжээ авах вэ?

Х: Ерөнхийлөгчийн сонгуулийн саналын хуудасны загвар, тоо, түүнийг хэвлүүлэх, хадгалах, хүргүүлэх, хамгаалах журмыг Сонгуулийн ерөнхий хороо баталсан. Тэгэхдээ саналын хуудас нь тусгай нууцлалтай, нэгдсэн таних нууц тэмдэгтэй учир хуурамчаар үйлдэх боломжгүй. Саналын хуудас нь нэр дэвшигчдийн нэр, зураг бүхий 1 хуудас байна.

А: Би яаж саналаа өгөх вэ? Буруу тэмдэглэгээ хийвэл яах вэ.

Х: Та саналаа өгөхдөө 1 нэр дэвшигчийн нэр өмнөх улаан тойрог дотор будна. Хэрэв дутуу, эсвэл илүү тэмдэглэсэн /будсан/ бол таны санал хүчингүй болох тул саналын хуудсанд бичигдсэн болон санал тэмдэглэх бүхээгт байх санал тэмдэглэх зааврыг сайн уншаарай.

Хэрэв та саналын хуудсанд буруу тэмдэглэл хийсэн гэж үзвэл санал тоолох төхөөрөмжид саналын хуудсаа хийхээс өмнө хэсгийн хорооны гишүүнд мэдэгдэн дахин нэг удаа саналын хуудас авах боломжтой.

А: Сонгуулийн ажиглагч хийхэд ямар эрх үүрэгтэйгээр санал авах байранд ажилладаг, хэн хаанаас томилдог бол?

Х: Нэр дэвшигч нэг санал авах байранд гурав хүртэл Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлсэн төрийн бус байгууллага, хоёр хүртэл сонгуулийн ажиглагч томилон сонгуулийн үйл явцыг ажиглуулдаг.

Ажиглагч нь сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, санал авах, тоолох, дүн гаргах үед уг ажлыг сонгуулийн тухай хууль тогтоомжийн дагуу явуулж байгаа эсэхийг зөвхөн хөндлөнгөөс ажиглан хянах үүрэгтэй.

Тэгэхдээ сонгогчдын нэрийн жагсаалт болон саналын хуудасны битүүмжлэгдсэн байдалтай танилцах, санал тоолох ажлыг ажиглах, бие даан нэр дэвшигчийн дэмжигч-сонгогчдын гарын үсэг цуглуулсан маягттай танилцах эрхтэй. Улмаар зөөврийн битүүмжилсэн саналын хайрцагар санал авах сонгогчдын нэрийн жагсаалт, тэднээс санал авах чиглэл, хуваарь, санал бэлтгэх бүхээг, зөөврийн битүүмжилсэн саналын хайрцаг, санал тоолох төхөөрөмж болон санал авах байр хууль тогтоомжийн дагуу бэлтгэгдсэн эсэхтэй танилцахыг хуулиар зөвшөөрдөг. Мөн сонгуулийн санал авах үйл явцыг бүхэлд нь ажиглаж болохуйц суудалтай байх, ямарваа нэгэн зөрчил гарвал хэсгийн хорооны даргад мэдэгдэж, залруулахыг хүсэх, илэрсэн зөрчлийн талаар тэмдэглэл хөтлөх, дуу, дүрс бичлэгийн хэрэгсэл ашиглан баталгаажуулах, гэрчээр гарын үсэг зуруулах, хэсгийн хорооны гишүүдээс холбогдох мэдээлэл авах, ажиглалтын тайлангаа нийтэд мэдээлэх, хэвлэн нийтлэх эрх эдэлдэг.

А: Санал хураалтын дараа маргаантай асуудал гардаг. Ажиглагчийн хувьд санал хураалтын дүнг тухайн цагт нь баримтжуулах бололцоо байдаг уу?

Х: Болно. Тэгэхдээ нэр дэвшигчийн төлөөллийн тус бүр нэг ажиглагч хэсэгт санал хураалт дууссаны дараа тухайн хэсэг дэх санал тэмдэглэсэн саналын хуудасны зурган болон тоон үзүүлэлтийг цахим хэлбэрээр хуулбарлан авч болно.

А: сонгуулийн үеэр хэсгийн хороон дээр саналын хуудсыг дахин тоолох асуудлууд багагүй гарч байсан. Яг ямар шалтгаанаар ингэж сонгогчдын саналын хуудсыг дахин тоолдог юм бэ?

Х:- Санал авахад зарцуулсан болон зарцуулагдалгүй үлдсэн саналын хуудасны нийлбэр нь тухайн хэсгийн хороо хүлээн авсан нийт саналын хуудасны тооноос зөрвөл хэсгийн хороо шалтгааныг шалгаж тогтоох ёстой. Шаардлагатай гэж үзвэл саналын хуудсыг нэн даруй дахин тоолдог юм. Үүнээс өөр шалтгаанаар саналын хуудсыг дахин тоолохыг хориглодог.

А: Хүмүүс сонгогчдын саналыг автомат машинаар тоолно гэхээр нэг зүйлээс болгоомжилж байгаа. Энэ нь санал тоолох машины мэдээллийн аюулгүй байдал, бас хөндлөнгөөс санал тоолох ажиллагаанд нөлөөлөх зэрэгт эргэлзэж байгаатай холбоотой?

Х: Сонгуулийн тухай хууль тогтоомжийн дагуу санал тооллогын дүнг ямар үзүүлэлтээр яаж гаргах вэ, саналын нууцлалыг хэрхэн хангах вэ, мэдээллийн аюулгүй байдлыг хэрхэн хангах вэ гэдэг асуудалд гол анхаарлаа хандуулж ажиллаж байна. Энэ ажилд төрийн байгууллагууд, төрийн бус байгууллагууд, сонгуульд оролцогч нам, эвслүүд хамтран хяналт тавин ажиллаж байна. АНУ-ын “Dominion voting” компанийн Image Cast загварын санал тоолох төхөөрөмжийг ашиглан сонгуулийн санал хураалтыг зохион байгуулна. Энэ төхөөрөмжөөр сонгогчийн санал хураах ажиллагааг явуулахад уг машин нь ямар нэгэн сүлжээнд холбогдолгүйгээр, сонгогчийн саналын хуудасны мэдээллийг тусгайлсан програмын тусламжтай нэгтгэх бөгөөд уг машинд уншигдсан бүх

саналын хуудсыг зурган хэлбэрээр хадгалдаг. Санал тоолох төхөөрөмжийн болон сонгогчийн бүртгэлийн програм хангамжийг сонгуулиас өмнө туршин шалгаж баталгаажуулсны дараа ашиглана Тэгээд ч санал тоолох машины зохион байгуулалт битүү сүлжээнд ажиллах зарчмаар бүтээгдсэн учраас найдвартай байдлыг хангасан гэж дүгнэж байна. Кодтой, түлхүүртэй, нууцлалтай. Цахилгаан тасарсан тохиолдолд автоматаар батарейгаараа ажиллах горимд шилжиж 12-13 цаг тасралтгүй ажиллах боломжтой.

А: Санал тоолох машиныг сонгуулийн санал авах өдөр л ашиглах юм уу эсвэл урьдчилан туршсан байх уу?

Х: Сонгуулийн автоматжуулсан системийн автоматжуулах хэрэгслийн иж бүрдэл, программ хангамжийг урьдчилан туршихгүйгээр сонгуулийн үйл ажиллагаанд ашиглахыг хориглосон. Тиймээс автоматжуулсан систем, хэрэгслийн иж бүрдлийг Сонгуулийн ерөнхий хорооноос гаргасан журмын дагуу хууль хяналтын байгууллага, мэргэжлийн байгууллага, төрийн бус байгууллага болон нам, эвслийн томилсон ажиглагчдыг оролцуулан турших учиртай. Эцэст нь Автоматжуулах хэрэгслийн иж бүрдэлд орсон техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг шалган туршиж, түүний бэлэн байдлыг баталгаажуулсан тухай гэрчилгээг техник хэрэгсэл, програм хангамж тус бүрд олгоно.

А: Санал тоолох автомат машины хүчин чадал, яаж ажилладаг талаар танилцуулж өгнө үү?

Х: Бид АНУ-ын “Dominion Voting Systems” компанитай гэрээ байгуулж, 2500 машин захиалсан нь бүгд ирээд туршилтанд орсон. Энэ машин нь нэг хуудсыг 5-8 секундэд тоолох хүчин чадалтай. Хуурамч болон шаардлага хангахгүй, стандартын бус саналын хуудсыг ялгах чадвартай. Сонгогч саналаа зааварт заасны дагуу тэмдэглэсний дараа санал авах төхөөрөмжийн саналын хуудсыг хийх зориулалтын хэсэгт чиглүүлэн тулгаж барихад саналын хуудсыг автоматаар татаж авч таны тэмдэглэсэн саналын дүнг нь боловсруулан санамжиндаа хадгална. Санал хураалт 20 цагт дууссаны дараа дүнг нэгтгэн хэвлэн гаргана. Ямар нэгэн сүлжээнд холбогдохгүй ажилладаг учраас хөндлөнгөөс нөлөөлөх боломжгүй. Программ хангамжаас шалтгаалан алдаа гарахгүй. Учир нь хууль хяналтын болон бусад холбогдох төрийн байгууллага, төрийн бус байгуулагуудын төлөөлөл, улс төрийн намуудын оролцоотойгоор хяналт тавьж зохих туршилтыг явуулж гэрчилгээжүүлсэн. Машин бүр 12-13 цаг ажиллах хүчин чадалтай батарейтай учир эрчим хүчний тасалдал гарсан ч найдвартай ажиллана.

А: Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хууль тогтоомжийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг хаанаас авч болох вэ.

Х: Монгол Улсын иргэн Сонгогчийн эрхээ эдлэхэд нь зориулж, сонгогчдын нэрийн жагсаалт, санал авах байрны байршил, саналаа хэрхэн өгөх зэрэг сонгуулийн хууль тогтоомжтой холбоотой бүхий л мэдээллийг нэг дороос авах боломжтой Монгол Улсын сонгуулийн ерөнхий хорооны пайж хуудас, сонгогчийн 1800-2800

утас ажиллаж байна. Та бүхнийг мэдээллээ үнэн зөв, түргэн шуурхай авахад туслах болно.